



САЙНЦАГААН СУМЫН ДӨРӨВ
ДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
С.АЛИМАА ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ДУНДГОВЬ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР
АКТ

48090 Дундговь аймаг,
Сайнцагаан сум, Нарлаг баг
Утас: 70-59-24-39, 70-59-22-08, 70-59-32-08
E-mail: dundgovi@audit.gov.mn

2017.02.24 № 01/22 ДУА-2017/94/СТА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд аймгийн Аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Сайнцагаан сумын Дөрөв дүгээр цэцэрлэгийн 2016 оны санхүүгийн тайланд аудит хийх явцад ажилтан, албан хаагчдад тулээ, нүүрсний хөнгөлөлт олгоходо нийгмийн даатгалын шимтгэл суутгаж тооцсон дүнгээс хувь хүний орлогын албан татварыг тооцож **28,300.00 / Хорин найман мянга гурван зуун/ төгрөгийг илүү олгосон зөрчил илрээ.**

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 15 дугаар зүйл буюу шууд бус орлого 15.1.2-т /орон сууцны ашиглалтын зардлын төлбөр, бэлнээр олгосон байрны холс, түлиний зардал/, 22 дугаар зүйлийн 22.1.4.-т /шууд бус орлогод ногдуулах албан татварыг тухайн орлогын дүнгээр./ 23 дугаар зүйлийн 23.1-т /Энэ хуулийн 17-19 дүгээр зүйл, 20.1.2-20.1.5, 22.1.4-т зааснаар тодорхойлсон орлогын жилийн дунд 10 хувиар тооцож албан татвар ногдуулна/ заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага огох, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд торийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжсээч, аудитор, шинжсээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1.3-т /Бусдаад өгөх төлбөр тооцоог зөрүүтэй тооцоолж олгосон/ заасан заалтуудыг үндэслэн **ТОГТООХ** нь:

- Илүү тооцож олгосон **28,300.00 /Хорин найман мянга гурван зуун/ төгрөгийг холбогдох албан тушаалнаас суутган тооцож, Татварын хэлтсийн 100080000901 тоот дансанд төвлөрүүлэх;**

2. Актын биелэлтийг 2017 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор Аудитын газарт ирүүлэхийг Сайнцагаан сумын Дөрөвдүгээр цэцэрлэгийн эрхлэгч /С.Алимаа/, нягтлан бодогч /Ш.Лхагвасүрэн/ нарт хариуцуулав.

АКТЫГ

ТОГТООСОН¹:

АУДИТОР




Т.ОЮУН-ЭРДЭНЭ

ЗӨВШӨӨРСӨН:
Сайнцагаан сумын Гуравдугаар цэцэрлэгийн:

ЭРХЛЭГЧ

С.АЛИМАА

НЯГТЛАН БОДОГЧ



Ш.ЛХАГВАСҮРЭН

¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хургүүлнэ” гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хургүүлнэ.